МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ ХАМААРАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
/2024 оны жилийн эцсийн байдлаар/

Хүснэгт-2

| № | Зорилго, зорилт, арга хэмжээ | Төсөв /сая төг/ | | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтот түвшин | | Хэрэгжилт | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь | Хүрээгүй шалтгаан нөхцөлийн тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төсөвлөсөн | гүйцэтгэл | | он | түвшин | он | түвшин | | | |
| **Зорилго 4.Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно.** | | | | | | | | | | | |
| Зорилт 4.2. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ: | | | | | | | | | | | |
| 1. | 4.2.1. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдүүлнэ. | | | Бичил уурхайн хууль, журам АМТХ-ийн 42.1 дүгээр заалт хэрэгжс | 2019 | 17 аймаг, 34 сум, нийслэлийн 1 дүүргийн 178 нэгж талбайн 616.41 га газарт 2889 | 2024 | Бичил уурхайн журам хэрэгжилт хангагдсан байна. | 1. Дараах мэдээллийг хүлээн авч, уул уурхайн хэлтсийн дотоод санд нэгтгэв. Үүнд:<br>• Бичил уурхайн тайлан, мэдээ;<br>• Бичил уурхайн сургалтын мэдээ;<br>• Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ<br>2. Бичил уурхайн мэдээ, мэдээллээр хангасан. Үүнд: | 70 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эн байна. | | бичил уурхайчид олборлолт явуулж үүнээс эвдрэлд орсон талбайн хэмжээ 203.1 га, нөхөн сэргээсэн талбайн хэмжээ 62.7 га тус тус байна.* | | | • Бичил уурхайн журмын харьцуулсан судалгаа;<br>• ТЕГ-т 2023 оны үйл ажиллагааны мэдээ, тайлангийн нэгтгэл;<br>• УИХ-ын Хянан шалгах түр хороонд бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал;<br>• МБУНДХ-д АМГТГ-ын авч хэрэгжүүлсэн ажлын тайлан<br>3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн дүгнэлт гаргах дотоод хяналтын хуудасны мэргэжлийн шүүлт хийх ажлын хүрээнд **22 талбайн** ГБТА-д байгаа тайлан болон уг талбайд хамаарах хайгуулын тусгай зөвшөөрлийн жилийн төлөвлөгөө, тайлангаас холбогдох зураг, материалыг авч, эдийн засгийн үр ашиггүй орд, үүсмэл талбай байх боломжтой эсэх талаар дотоод хяналтын хуудсанд тэмдэглэл үйлдэв.<br><br>Үүнд:<br>Хэнтий аймгийн Баян-Адрага сумын<br>• Хөлийн холбоо;<br>• Хөлийн холбоо-Есөн Эрдэнэ Адрага;<br>• Хөлийн холбоо-1;<br>• Хөлийн холбоо-2;<br>• Чойлон-Уул;<br>• Хөлийн холбоо Ашид дэлгэрэх эрдэнэс;<br>• Хөлийн холбоо Жинжин хур;<br>• Хөлийн холбоо Хайрхан баялаг эрдэнэс; | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Баянхонгор аймгийн Заг сумын Баянхонгор аймгийн Заг сумын Түүхий хөндий 8<br>Говь-Алтай аймгийн Дарив сумын Дэрстэйн эхний улаан толгой<br>Төв аймгийн Заамар сумын<br>• Салтгарын ам-4;<br>• Туулын гүүр-2;<br>Говь-Алтай аймгийн Тонхил сумын<br>• Эрэмгий хөх ар;<br>• Талбай-1;<br>• Талбай-2;<br>Дорноговь аймгийн Айраг сумын Ам цагаан хайрт<br>Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын<br>• Цагаан гозгор;<br>• Баянгол-1;<br>• Баянгол 2;<br>• Хамар буян адаг;<br>Хэнтий аймгийн Батноров сумын Улаан-Өндөр;<br>Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Сүж. | | |
| 2. | 4.2.11.<br>Эрдэс баялгийн экспортын зонхилох хувийг эзэлж байгаа нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть зэргийг нэмүү өртөг, үнэ цэнэ шингээн боловсруулж, экспортлох хүрээнд нүүрс-химийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтыг нэн яаралтай эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох төмөр зам, | | | Экспорт<br><br>сая ам. Доллар /Нүүрс/ | | | 2024 | - | 2024 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар 122 аж ахуйн нэгж нийт 10 хилийн боомтоор 77.4 сая.тн нүүрс экспортолсон байна.<br>Ашигт малтмалын газрын даргын 2009 оны “Монгол Улсын хилээр шинжилгээний дээж нэвтрүүлэхэд тодорхойлолт олгох заавар”-ын дагуу материалаа бүрдүүлэхийг зөвлөж, 154 дээжийн тодорхойлолтыг Гаалийн ерөнхий газрын харьяа газруудад хүргүүлсэн. | 100 | |
| | | | | Экспорт<br><br>сая ам. Доллар /Газрын тос/ | 2020 | 4.06 сая баррель буюу 553.9 мянган тонн | 2024 | 6.5 сая баррель буюу 883 мянган тонн | 2024 онд газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Тосон Уул XIX, Тамсаг XXI, 1997 оны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайнуудаас 4.85 сая баррель буюу 659.2 мянган тонн газрын тос олборлох төлөвлөгөөтэй байгаагаас хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2024 оны 12 дугаар сарын | 70 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ус, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлнэ. | | | | | | | | байдлаар 4.19 сая баррель буюу 562.6 мянган тонн газрын тос олборлож, төлөвлөгөөний биелэлт 85.0 хувь байхаар байна. Газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2024 онд Тамсаг XXI талбайд хэвтээ 5 цооног өрөмдөж шингэн хагалбар перфораци хийх, 5 босоо цооног өрөмдөх, 10 хуучин цооногт шингэн хагалбар, Тосон Уул XIX талбайд цооногийн мөргөцгийн хажуу өрөмдлөг 5 цооног, хуучин 5 цооногт том хэмжээний шингэн хагалбар хийх, 1997 оны БХГ-т талбайд 5 цооног шинээр өрөмдөж перфораци, шингэн хагалбар хийх, 10 хуучин цооног сэргээн ашиглалтад оруулах ажлын төсөв, төлөвлөгөө батлагдсан. Матад XX талбайг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 256 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан бөгөөд 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Матад сумын засаг даргын А/76 тоот тушаалаар Матад суманд газар ашиглах захирамж олгосноор Дорнод аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт ажил гүйцэтгэх А даалгаврын хүсэлтийг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр цахимаар хүргүүлснээр олборлолтын үйл ажиллагааг явуулах нөхцөл бүрдэж 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Цэнтогоруу цооногийн олборлолтыг эхлүүлсэн. Өнөөдрийн байдлаар хоногт 200 орчим баррель газрын тос олборлон, экспортолж байна. Тус онд газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Тосон-Уул XIX талбайд 5 цооног, Тамсаг XXI талбайд 7 цооног, БХГ-97 талбайд 2 цооног тус тус шинээр өрөмдсөн болно. | | |
| | | | - | Экспорт сая ам. Доллар | 2020 | 23.6 тн | 2024 | 12.96 тн | 2024 оны 12 дугээр сарын 01-ний өдрийн байдлаар нийт 76 ААН, 19 иргэд 13.39 тн алтыг Монгол банканд тушаасан. Мөн 2024 онд | 90 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | /Алт/ | | | | | экспортолсон алтны хэмжээ 11.14 тн буюу 665.1 сая ам.доллар хүрсэн. | | |
| | Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь | | | Хувь | 2020 | 15 | 2025 | 80 | 2020 онд 1.9 сая тонн шатахуун импортолсны 13 хувийг Евро 5 стандартын шатахуун, 2021 онд 1.8 сая тонн шатахуун импортолсны 18 хувийг Евро 5 стандартын шатахуун, 2022 онд 1.9 сая тонн шатахуун импортолсны 22 хувийг Евро 5 стандартын шатахуун тус тус эзэлж байсан байна.<br>2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 2.1 сая тонн шатахуун импортолсны 14 хувийг Евро 5 стандартын шатахуун эзэлсэн байна.<br>2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар нийт 2.5 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх төрлийн шатахуун 2.3 сая тонн, үүнээс К5 /Евро-5/ ангиллын шатахуун 331.6 мянган тонн буюу нийт шатахууны 14.3 хувийг эзэлж байна. Өнгөрсөн 2023 оны мөн үетэй харьцуулахад /Евро-5/ ангиллын шатахууны нийт импорт 43 хувиар өссөн дүнтэй байна. | 70 | |
| | Багануур ХК-ийн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл Улаанбаатар | 67,778.4 | | | | | 2020 - 2021 | | Улаанбаатар хотын Багануур дүүргийн нутагт орших Багануурын хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хяналтын хуудсаар хянаж, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн СТР/24-02 дугаар өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж СТР/24-02-02 тоот дүгнэлтээр бүртгэж авсан. | 70 | |
| | Шивээ Овоо ХК-ийн их уурхайн технологийн шинэчлэл төсөл Говьсүмбэр | 46,279.6 | | | | | 2020 - 2025 | | 1.Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайтай холбоотой арга хэмжээний биелэлтийн тайланг ирүүлэх, яам, агентлагаар дамжуулан | 70 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | шийдвэрлүүлэх санал, хүсэлт ирүүлэх тухай албан бичгийг "Багануур" ХК-д хүргүүлсэн.<br>2. Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлэх өртөг, зардлыг бууруулахад шаардлагатай мэдээлэл авах зорилгоор "Багануур" ХК-руу 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 1/5494, "Шивээ-Овоо" ХК-руу 1/5495 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлж, уурхайн технологийн шинэчлэлтэй холбогдолтой мэдээллийг авч нэгтгэн УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаярт цахим шуудангаар хүргүүлсэн. | | |
| | Газрын тос дамжуулах хоолой барих төсөл Дорноговь | 1,000,000.0 | | | | | 2020-2024 | | Аж үйлдвэр эрдэс баялгийн яам | | |
| | Үндэсний алт цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл Улаанбаатар | 233,028.9 | | | | | 2021-2024 | | Аж үйлдвэр эрдэс баялгийн яам | | |
| Зорилт 4.6. Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ: | | | | | | | | | | | |
| 3. | 4.6.1. Хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлсэн байна. | | | | | | | | Аж үйлдвэр эрдэс баялгийн яам | | |
| | Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах | 1,013,262.9 2016-2023 | | | | Төслийн ажлын явц 10 хувь Төслийг эхлүүлсэн. | 2021 | Төслийн ажлын явц 40 хувь. Төслийн ажлыг үргэлжлүүлнэ. | Аж үйлдвэр эрдэс баялгийн яам | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл. | 83,685.5<br>2021<br>-<br>2022 | - | | 2020 | - | 2024 | - | Аж үйлдвэр эрдэс баялгийн яам | | |
| | Эрдэнэтийн баяжуулах үйлдвэрт өргөтгөл, шинэчлэл, ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг байгуулах төсөл | 369,317.3<br>2020<br>-<br>2025 | - | Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна. | 2020 | - | 2023 | Төслийн ажлын явц 100 хувь. Төсөл бүрэн хэрэгжиж дуусна | Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн хөрөнгө оруулалт 100 хувьтай байгаа ба төслийн ажлын явц 97 хувьтай байна.<br>Мөчлөгт урсгалт тээврийн системийг 2025 онд Төслийг бүрэн дуусгаж ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа. | 97 | |
| | Цагаансуваргын зэс, молибдений ордыг ашиглалтад оруулах төсөл | -<br>2020<br>-<br>2022 | - | Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна. | 2020 | - | 2024 | - | 1. Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжилтийн мэдээлэл авахаар 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1/4814 тоот албан бичгийг Эрдэнэс Цагаан суварга ХХК-д хүргүүлэв.<br>2. Төслийн бүтээн байгуулалт үргэлжилж байгаа ба гүйцэтгэлийн төлөвийг дор үзүүлэв. Үүнд:<br>- Зураг төсөл - 90%,<br>- Газар шороо - 90%,<br>- Барилга бүтээц - 90%,<br>- Металл хийц - 61%,<br>- Сэндвич хана - 36%,<br>- Цахилгаан угсралт - 25%,<br>- Шугам хоолой - 6% | 50 | |
| | Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл | 123,446.0<br>2021<br>-<br>2025 | | | | | 2024 | - | Аж үйлдвэр эрдэс баялгийн яам | | |
| | Тавантолгойн нүүрсний бүлэг ордод технологийн шинэчлэл | 772,590.5 | | | | | 2024 | Нүүрс, хөрс тээврийн | 1. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой чулуун нүүрсний бүлэг | 70 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хийж, олборлолтыг төслийн хүчин чадалд хүргэх, нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах төсөл | 2020 - 2024 | | | | | | конвейрын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 50 хувьд хүрнэ. | ордын ил уурхайн хөрс, нүүрс тээвэрт авто-конвейерийн хосолсон тээвэр бүхий мөчлөг-урсгал технологи нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг хяналтын хуудсаар хянаж, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн СТР/23-05 дугаар өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлэн СТР/23-05-01 тоот зөвлөмжийг гаргаж тус компанид хүргүүлсэн.<br>2. 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/08 дугаар тушаалын дагуу томилогдсон "Таван Толгой" ХК-ийн нүүрс ачиж, буулгах ложистик төвийн төслийн тоног төхөөрөмж, барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комисст 2024 оны 09 дүгээр сарын 02- 03-ны өдөр УУХ-ийн дарга Т.Зууннаст, мэргэжилтэн Д.Цолмонтуяа нар ажиллаж үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, холбогдох дүгнэлтийг гаргаж, ашиглалтад зөвлөмжтэй хүлээж авсан. | | |
| | Рашаант дахь улсын нөөцийн агуулах төсөл | 6,702 .9 2020 - 2025 | | | | | 2024 | Төслийн ажлын явц 100 хувь. Төсөл бүрэн хэрэгжиж дуусна. | Аж үйлдвэр эрдэс баялгийн яам | | |
| | Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх | 1,484 .5 2022 - 2024 | | Үнэн зөв, бодитой мэдээл эл хүргүүл сэн байна. | 2020 | - | 2024 | Ордын ТЭЗҮ-ийг боловсруулж, ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээний талаарх санал боловсруулна. | 1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Асгатын мөнгөний ордтой холбоотой арга хэмжээний биелэлтийн тайланг ирүүлэх, яам, агентлагаар дамжуулан шийдвэрлүүлэх санал, хүсэлт ирүүлэх тухай албан бичгийг "Эрдэнэс монгол" ХХК-д 2023.06.16 өдрийн 1/3116, 2023.11.28 өдрийн 1/5555 тоотоор тус тус хүргүүлсэн | 70 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2.Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Асгатын мөнгөний ордтой холбоотой арга хэмжээний биелэлтийн тайланг ирүүлэх, яам, агентлагаар дамжуулан шийдвэрлүүлэх санал, хүсэлт ирүүлэх тухай 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 11/3275 дугаар албан бичгийг "Эрдэнэс монгол" ХХК-д хүргүүлсэн.<br>3. Асгатын мөнгөний ордыг нөөцийг ОУ-ын "Жорк" ангилалд нийцүүлэх ажлыг эхлүүлсэн. Хайгуулын ажилд шаардлагатай зам засах, хэвтээ ам нээх, гадаргуугийн бүрэн зураглал буюу топо геодези, хэвтээ малталтын 3-н хэмжээст зураглал, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээний ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Санхүүжилтийг "Эрдэнэс Монгол" нэгдэл өөрийн хөрөнгөөр бүрэн шийдвэрлэв | | |
| | Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах төсөл | 39,500.0 2021 | - | Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна. | 2020 | - | 2024 | Төслийн ажлын явц 100 хувь. Төсөл бүрэн хэрэгжиж дуусна. | - Монголросцветмет ТӨҮГ-ын MV-011722 тусгай зөвшөөрөлтэй Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайн 2023 оны уулын ажлын тайлан 2024 оны 01 дүгээр сарын 22-ний өдөр, 2024 оны уулын ажлын төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хянаж, холбогдох засвар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч тайланг хүлээн авсан | 70 | |
| | Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглах төсөл | 46,199.9 2021 | - | Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна. | 2020 | - | 2024 | - | Салхитын мөнгөний ордын 2024 оны уулын ажлын төлөвлөгөөтэй танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, албажуулж ажилласан. | 90 | |
| **Зорилго 6. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.** | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 6.2. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгоно: | | | | | | | | | | | |
| 4. | 6.2.4. Хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газрыг 22.9 хувиас нэмэгдүүлэхгүй тогтоон барьж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 8000 га талбайд нөхөн сэргээлт хийнэ. | Хуул иар тусгайлан хөрөнгө шаардлагагүй | - | Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ | 2019 | 812 га | 2024 | Жилд дунджаар 2000 га талбайг нөхөн сэргээх | 1.Оюу толгой" ХХК "100 сая мод" хөтөлбөрийн хүрээнд 100 сая мод тарих амлалтынхаа хүрээнд дүйцүүлэх хэлбэрээр 2023 онд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Ялбаг гэх газар хууль бус аргаар алт олборлогчдын нөлөөгөөр эвдэрч орхигдсон 400 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 2024 онд Дархан-Уул аймгийн Шарын гол, Хонгор сумын нутагт эвдрэлд орсон 215 га талбайг холбогдох стандартын дагуу нөхөн сэргээж орон нутагт хүлээлгэж өгсөн.<br><br>2."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын нийгмийн хариуцлага, дүйцүүлэн хамгааллын хүрээнд 2023 онд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Харганат, Могойт, Цамхаг, Гозон зэрэг газруудад хууль бус үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 1229 га талбай, 2024 онд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын "Нарийны ам" нэртэй газарт 777.6 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрх бүхий "Жинжий майнинг" ХХК, "Тотал идеал" ХХК-иар тус тус гүйцэтгүүлж орон нутагт актаар хүлээлгэж өгсөн.<br><br>3. 2024 оны жилийн эцсийн байдлаар албажсан 194 тайлангаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 860.95 га талбайд 13.4 сая ширхэг мод тарьсан байна.<br>4. 2024 оны ашиглалтын үйл ажиллагааны албажсан 366 төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 937.0 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 969.6 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 118,414.9 га талбайд нөхөн | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | сэргээлт хийхээр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 онд 4,231.8 га талбайд 18.2 сая мод тарихаар тусгуулан ажилласан. | | |
| **Зорилго 7. Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.** | | | | | | | | | | | |
| Зорилт 7.3. Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ: | | | | | | | | | | | |
| 5. | 7.3.4. Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан хүнсний агуулах, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулна. | /-/ | /-/ | Агуулах барих шийдвэр, санхүүжилт | /-/ | /-/ | /-/ | /-/ | Аж үйлдвэр эрдэс баялгийн яам | | |

Жич: Засгийн газрын хуралдааны 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 21 дүгээр тэмдэглэлд
“Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой зааж байх, үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлж байх”-ыг Засгийн газрын гишүүд, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгосон тул тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээ болон шаардлагатай суурь түвшин, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин зэргийг тодорхойлж бичнэ үү.